

ИННО ХИМИ ЛАБ ХХК



ИННО ХИМИ ЛАБ ХХК

7 хоногийн мэдээлэл

МЭДЭЭЛЛИЙН НЭР:

**Гүржийн хүнсний аюулгүй байдлыг хэмжих
хүнсний хяналтын системийн цахимжилт**

*(Энэхүү орчуулга нь албан бус орчуулга
болно)*

Утас: 77051414

И-мэйл: info@innocchem.mn

Вэбсайт: www.medimpex.mn

Фэйсбүүк:

Инно лаборатори

Agilent Demo Center

НҮБ-ын Хүнс, Хөдөө аж ахуйн байгууллагууд**Онцлох мэдээлэлүүд**

Хүнсний аюулгүй байдлыг хангах, дүрэм журмыг дагаж мөрдөхийн тулд нийтийн хүнсний хяналтын үйл ажиллагааны явцад үр дүнтэй мэдээлэл цуглуулах нь чухал юм. Гүрж улс саяхнаас бүтээмж багатай, алдаа гаргах эрсдэл өндөртэй цахим бус хүнсний хяналтын системээс дата цуглуулах болон хүнсний хяналтад дүн шинжилгээ хийх үйл ажиллагааг орчин үеийн болгох зорилгоор цахим систем рүү шилжлээ.

Цахим систем нь хүнсний аюулгүй байдлын тохирлын одоогийн түвшин, бодит цаг хугацаанд нь үнэлэх суурь үзүүлэлт, цаашдын чиг хандлагад дүн шинжилгээ хийх боломжийг олгодог бөгөөд хүнсний хяналтын үр дүнд суурилсан зорилтыг дэвшүүлж, төлөвлөгөөт арга хэмжээг авах боломжийг олгодог.

Энэхүү систем нь Гүржийн хүнсний хяналтын үйл ажиллагааг эрсдэлд суурилсан төлөвлөлтийг хийхэд бодит хувь нэмэр оруулж байна. Системийн программ хангамж нь системд байгаа дата мэдээлэл, тухайлбал хүнсний төрөл, үйл ажиллагааны чиглэл, дүрэм журмын хүрээнд ажилласан байсан эсэх гэх мэт дата өгөгдөлд үндэслэн Хүнсний бизнесийн операторуудыг (FBOs) оноогоор дүгнэдэг.

Хүнсний аюулгүй байдлын бүх мэдээлэл, үйл ажиллагааг багтаасан цахим системийг бий болгох нь нарийн төвөгтэй бөгөөд цаг хугацаа шаардсан ажил юм. Алхам алхмаар эдгээр мэдээллүүдийг нэгтгэн өргөжүүлэх нь системийн үр дүнг туршиж, сайжруулах боломжийг олгодог.

Оролцогч байгууллагууд:

Гүрж улсын Хүнсний аюулгүй байдлын агентлаг

Газар нутаг

Гүрж улс

Хүнсний аюулгүй байдлын гол асуудал

Хүнсний хяналтын бүтээмжийг сайжруулах

Танилцуулга

Хүнсний аюулгүй байдлыг хангах, дүрэм журмыг дагаж мөрдөхийн тулд төрийн эрх бүхий байгууллагаас хүнсний хяналтын үйл ажиллагааны явцад мэдээллийг үр дүнтэй цуглуулах нь маш чухал юм. Хүнсний бизнес эрхлэгчид, хүнсний хяналт шалгалт болон хүнсний хяналтын бусад үйл ажиллагаанаас мэдээлэл цуглуулж авахад орчин үеийн технологийг ашиглах нь чухал үүрэгтэй. Цахим системийн үр дүнд хүнсний аюулгүй байдлын дүрэм журмын хэрэгжилт, тохирлуудын түвшин ямар байгааг одоогийн бодит цаг хугацаанд нь үнэлэх, суурь үзүүлэлт болон цаашдын чиг хандлагад дүн шинжилгээ хийх боломжийг олгодог бөгөөд хүнсний хяналтын үр дүнд суурилсан зорилтот арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлэх боломжийг олгодог.

Сайн ажиллагаатай цахим системээс хүнсний аюулгүй байдлыг хэд хэдэн талаас харсан үр дүнг авах боломжтой бөгөөд хүнсний хяналтын эрх бүхий байгууллагад хүнсний хяналт, хүнсний аюулгүй байдлыг илүү үр дүнтэй болгохын тулд хаана сайжруулах шаардлагатай байгааг харуулж чаддаг. Өмнө нь хүнсний хяналтын мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийхэд ихэнхдээ цахим бус орчныг ашигладаг байсан. Гүрж улс сүүлийн жилүүдэд мэдээлэл цуглуулах системийг шинэчлэн, орчин үеийн болгохын тулд цахим системийг хөгжүүлж байна.



✓ 2017 он хүртэл Үндэсний Хүнсний Хяналтын Агентлаг бүс нутгуудаасаа хүнсний хяналтын талаарх үр дүн, мэдээ мэдээллийг хүснэгт болон бичмэл файл хэлбэрээр хүлээн авч байсан. Эдгээр файлуудаас мэдээлэл цуглуулах нь үр дүн муутай, нүсэр, алдаа гаргах магадлалтай байсан. Тухайлбал, Эрх бүхий байгууллагуудын хувьд хүнсний бизнес эрхлэгчдийн бүртгэл, хяналт шалгалтын дүн болон хүнсний аюулгүй байдлын бусад холбогдох мэдээлэл зэрэг хүнсний сүлжээн дэх мэдээллийг цаг тухайд нь хүлээн авах, цуглуулахад асуудлууд тулгардаг байжээ. Үүнээс шалтгаалан Гүрж улсын хүнсний аюулгүй байдлын нөхцөл байдлыг бодитоор ойлгож, хүнсний хяналтыг хөгжүүлэхэд анхаарч байна.

Шинэчлэгдсэн системийг 2017 оноос нийслэлдээ хэрэглэж эхэлсэн бөгөөд улмаар орон даяар нэвтрүүлэн хүрээг нь тэлж өргөжүүлсэн. Энэ системд хүнсний бизнесийн хүнсний аюулгүй байдал, дүрэм журмын хэрэгжилтийн талаарх хамгийн сүүлийн үеийн мэдээллүүдийг багтаасан байдаг. Гүрж улс хүнсний сүлжээний явцад бүртгэж, цуглуулж буй илүү их мэдээлэл оруулахаар энэхүү цахим системийг улам өргөжүүлэн хөгжүүлж байгаа бөгөөд үүний үр дүнд хүнсний аюулгүй байдлын төлөв байдал, хүнсний хяналтын бүтээмжийг бодитоор үнэлэх боломж нээгдэж байна.

Зорилт

Гүрж улсад хэрэгжүүлсэн төслийн зорилго нь хүнсний хяналтын бүх дата мэдээллүүдийг нэг орон зайд багтаасан цахим системийг хөгжүүлэх юм. Хүнсний бизнес эрхлэгчид (FBOs) болон тэдгээрийн үндэсний түвшинд тавигддаг дүрэм журмын шаардлагыг хэрхэн хэрэгжүүлж байгаа, хүнсний хяналтын хэрэгжилт болон хүнсний аюулгүй байдал, хүнсний хяналтын үр нөлөөг үнэлэхэд хамаарах бусад хяналтын дата мэдээллүүдийг хамгийн сүүлийн үеийн байдлаар гаргаж, боломжит шаардлагыг хангахад энэхүү систем хэрэгтэй байсан.

Хэрэгжүүлсэн арга зүй

Гүрж улс 2015 онд Хүнс, үйлдвэрлэл эрхлэгчдийг бүртгэх, хүнсний хяналтаар гарсан дата мэдээлэлтэй ажиллахад учир дутагдалтай, тус улсын хүнсний аюулгүй байдлын талаарх ерөнхий ойлголт хангалттай биш зэрэг нөхцөлд байдлын улмаас цахим системийг эх орондоо хөгжүүлэхээр шийдсэн. Энэ шийдвэр нь энэ төслийг

хэрэгжүүлэх эхний алхам байсан бөгөөд 2017 онд нийслэл Тбилисид, хоёр жилийн хугацаанд улс орон даяар амжилттай хэрэгжүүлжээ. Цахим системийг Үндэсний Хүнсний Агентлаг хөгжүүлсэн бөгөөд арилжааны программчлалын хэлийг ашиглан бүтээгдсэн. Хүнсний хяналтыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд эрх баригчид тус улсын бүх идэвхтэй Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг мэдэх шаардлагатай байсан.

Тиймээс төслийн хүрээнд хэрэгжүүлсэн хамгийн эхний ажил бол Үндэсний хүнсний газрын шинэ цахим мэдээллийн санд оруулахын тулд төрөл бүрийн бүртгэлийн эрх бүхий байгууллагуудаас идэвхтэй хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг тодорхойлох байжээ. Орлогын алба, Үндэсний Олон Нийтийн Бүртгэлийн Агентлаг зэрэг бусад эрх бүхий байгууллагууд тус хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийг тогтоохын тулд мэдээллээр хангах ажилд FBO-уудыг тодорхойлох, тэдний үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангахад оролцож ерөнхий зураглалыг гаргаж ирсэн. Хүнсний бүтээгдэхүүний хяналтын хяналт шалгалт болон хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн газарт хийсэн хяналтын талаарх мэдээллийг цуглуулах зорилготой байсан тул цахим хэлбэрт шилжүүлснээр хяналтын үйл явцыг бүхэлд нь хамарсан.

Хүнсний хяналтын байцаагчдыг зөөврийн таблет, принтерээр тоногдосон нь шалгалтын дүнг цахимаар шууд газар дээр нь гаргаж, хэвлэмэл хуудсыг хүнсний үйлдвэрлэл эрхлэгч нарт өгөх, шалгалтын үр дүнг Үндэсний Хүнсний Агентлагийн цахим мэдээллийн санд шуурхай дамжуулах боломжийг олгосон ач холбогдолтой.

Гол оролцогчид



- ✓ Үндэсний Хүнсний Агентлаг (IT системийг хөгжүүлэх, зохицуулах)
- ✓ Үндэсний Олон Нийтийн Бүртгэлийн Агентлаг (Хүнс үйлдвэрлэгчдийг бүртгэх)
- ✓ Орлогын газар (Хүнс үйлдвэрлэгчдийг ангилах)
- ✓ Үндэсний статистикийн газар (Хүнс үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг ангилах)

Үр дүн ба нөлөөлөл

Дижитал системийг хөгжүүлснээр Гүрж улсын мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх ажлыг эрс сайжруулсан. Хүнсний үндэсний газар одоо идэвхтэй хүнс үйлдвэрлэгчид болон тэдгээрийн дүрэм журмын хэрэгжилтийн дагаж мөрдөх байдлын талаарх хамгийн сүүлийн үеийн мэдээлэлтэй болсноор мэдлэгт суурилсан менежмент хийх чадамжтай болсон. Хяналт шалгалтын дүнгийн цахим баримт бичиг нь хүнсний аюулгүй байдлын тохирлын түвшинг тодорхойлсон маш олон төрлийн индикаторуудыг олон талт аргаар тооцоолох боломжтой. Тухайлбал, зөрчил гаргаж буй аж ахуйн нэгжийн тоо, зөрчлийн төрөл, тэдгээрийн цаг хугацааны явцад хэрхэн өөрчлөгдөж буй гэх мэт мэдээллийг харна. Эдгээр дата мэдээлэлд шалгалтын явцад гарсан шийтгэлийн мэдээлэл байдаг учраас хяналтын үйл ажиллагаанд тус арга хэмжээ хир үр дүнтэй байгааг үнэлэх боломжтой.



Дээрх систем нь хүнсний хяналтын үйл ажиллагааг төлөвлөхөд чухал ач холбогдолтой. Системийн программ хангамж Хүнс үйлдвэрлэл эрхлэгчдийг оноогоор үнэлдэг бөгөөд үүний тулд хүнсний төрөл, үйл ажиллагааны төрөл, эргэлтийн хэмжээ (үйл ажиллагааны хэмжээнээс хамаарч) болон дүрэм журмын хэрэгжилтийн түүх гэх мэт дата ашигладаг. Энэхүү оноог бүс нутгуудад эрсдэлд суурилсан хяналт шалгалтын төлөвлөгөөг гаргахад ашиглаж байна. Мөн системийг бүс нутгийн болон байцаагчийн түвшинд хүнсний хяналтын үр дүнг тооцоход ашигладаг.

Хяналт шалгалтын тоо зэрэг төлөвлөгөөт ажлуудын хэрэгжилтийг шалгаж, шаардлагатай үед бүсийн хэлтсүүдэд сануулга хүргүүлдэг.

Дижитал систем нь мэдээллийн хэмжээг нэмэгдүүлээд зогсохгүй, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх хугацааг өмнө нь шаардлагатай байсан хугацаанаас маш бага хэмжээнд хийх боломжтойгоор болгож бууруулсан. Нөхцөл байдлын дүн шинжилгээ, жилийн тайлан, ажлын хэсгүүдийн тайлан зэрэг мэдээллүүдийг богино хугацаанд авах боломжтой.

Амжилтанд нөлөөлсөн хүчин зүйлүүд

Хүнсний хяналтын мэдээллийн цуглуулах дижитал систем хөгжүүлэх нь хүнсний хяналтын байгууллагын мэдлэгт суурилсан менежментийг сайжруулах хэрэгцээ шаардлагын хүчтэй нөлөөгөөр хийгдсэн. Төслийн амжилттай хэрэгжилтэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн.

- Гүржийн 2021-2027 оны хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн стратегид тусгагдсан тус улсын хүнсний аюулгүй байдлыг сайжруулах улс төрийн амлалт
- Цаг хугацаа хэмнэх дижитал технологи ашиглахын ашиг тус, цаашид дүн шинжилгээ хийх боломжтой, бүтэц задаргаагаар ангилах өгөгдөлтэй байх нь хэрэгтэй болохыг тус тус хүлээн зөвшөөрсөн
- Өөрчлөлтийг хийхэд тууштай ажиллаж буй хүнсний хяналтын чадварлаг ажилтнууд

Зөрчил болон хязгаарлагдмал хүчин зүйл

Төслийн явцад дижитал системийг хөгжүүлэх санхүүжилт зэрэг зарим хязгаарлалтуудтай тулгарсан. Ашигласан программ хангамж нь хүнсний хяналтын бүх өгөгдлийг багтаах мэдээллийн цуглуулгыг өргөжүүлэхэд оновчтой биш тул үүнийг цаашид улам өргөжүүлэн сайжруулах шаардлагатай байна. Хяналтын үйл ажиллагаанд нөлөөлж буй зарим хууль тогтоомжийн шаардлагууд одоог хүртэл системд зохицуулагдаагүй байна.

Сургамж

Боломжит нөөцөөр бүтээгдсэн, арилжааны программчлалын хэл дээр бүтээгдсэн цахим систем нь анхны зорилгодоо хүрч сайн ажилласан. Гэсэн хэдий ч, илүү нарийн мэдээлэл цуглуулах хэрэгцээ нэмэгдэхийн хэрээр одоогийн программ хангамж нь эрх баригчдын хүссэн шиг уян хатан, зориулалтын дагуу ашиглахад шаардлага хангахуйц байж чадахгүй юм. Цахим системийг хөгжүүлэлтийн зөвхөн эхний шатанд төдийгүй дараа нь системийг шинэчлэх шаардлагатай үед мэдээллийн технологийн мэргэжилтнүүд хангалттай байх хэрэгтэй.

Тогтвортой байдал



Цахим систем нь Гүрж улсын хүнсний аюулгүй байдлын засаглалыг сайжруулж, хүнсний аюулгүй байдлыг сайжруулсан. Системийн давуу тал нь илт харагдаж байгаа бөгөөд эрх баригчид системийг үргэлжлүүлэн ашиглах, хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй байна. Системийн ирээдүйн хөгжил нь боломжит нөөцөөс хамаарахаар байна. Нөөцийн хуваарилалтыг үнэлэхдээ хүнсний хяналт нь эхнээсээ хүнсний аюулгүй байдлыг нэмэгдүүлж, шударга ил тод худалдааг сайжруулж, хоол хүнсээр дамжих өвчлөлийг бууруулах нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх байдлаар эргээд нийгэмдээ өгөөж үр дүн хүргэдэг үйл ажиллагаа гэдгийг ойлгох нь чухал.

Загварыг олшруулах болон өргөжүүлэн дараагийн түвшинд гарах

Хүнсний асуудал хариуцдаг эрх баригчдын зүгээс хүнсний аюулгүй байдал, хяналтын мэдээллийг цогцоор нь багтаахын тулд системийг сайжруулахаар төлөвлөж байна. Мэдээллийн технологийн хөтөлбөр, нөөц боломжийн асуудал тодорхой болмогц хоол хүнсээр дамждаг дэгдэлтийн мэдээлэл, хоол хүнсээр дамжих эмгэг төрүүлэгчдийн халдварын тохиолдлуудыг оруулах болно. Шинжилгээнд хамрагдсан түүврийн мэдээллийг цуглуулж оруулсан боловч лабораторийн шинжилгээний үр дүнг хараахан системд нэгтгээгүй байна. Эдгээр үзүүлэлтүүдийг нэмснээр хүнсний аюулгүй байдал, хүнсний хяналтын үр нөлөөг олон талаар хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг бий болгох боломжийг олгох болно.

Энэхүү төсөл нь хүнсний хяналтыг цахим болгосны ач холбогдол болон тулгарч болох сөрөг талуудыг харуулсан сайн жишээ болж байна. Төслийг хэрэгжүүлсний үр дүнд хүнсний аюулгүй байдлыг хэмжихэд гарч буй эерэг өөрчлөлт, хүнсний аюулгүй байдлыг хяналтын бүтээмжид гарсан сайжруулалтыг нотолгоотойгоор харуулж чадаж байгаа учраас бусад улс орнууд ч гэсэн өөрсдийн хүнсний аюулгүй байдлын системийг цахимжуулах алхам хийхэд түлхэц болж өгнө.

Дүгнэлт

Цахим системийг боловсруулахаас өмнө Гүрж улс хүнсний аюулгүй байдлын түвшинд нөхцөл байдлын дүр зургийг гаргаж ирэхэд асуудалтай тулгарч байсан. Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй хүнс, бизнес эрхлэгчдийн талаарх мэдлэг болон тэдгээрийн дүрэм журмын мөрдөлтийн талаарх мэдээлэл шаардлагатай түвшинд байхгүй, мөн хүнсний хяналтын мэдээлэл цуглуулах нь хэцүү байсан учир дүн шинжилгээ, тайлагнах үйл ажиллагаанд хангалттай мэдээлэл болж чаддаггүй байсан.

Хүнсний аюулгүй байдлыг сайжруулах үндэсний стратегийн дагуу Гүржийн Үндэсний Хүнсний агентлагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь Гүрж улсад хүнсний аюулгүй байдал, мэдээллийн дүн шинжилгээ хийх боломжтой цахим орчин хөгжүүлэх нөхцөлийг бий болголоо. Энэ нь тус улсын хүнсний аюулгүй байдлын талаарх мэдлэгийг нэмэгдүүлж, хүнсний хяналтад хийсэн үйл ажиллагааг үнэлэх боломжийг олгож, дата өгөгдөлд суурилсан тайлан гаргаж нөөцийг зөв хуваарилж хэмнэх боломжийг олгож байна.



Хүнсний үндэсний агентлагийн зүгээс цахим системийг сайжруулан, байгаа нөөцийн хүрээнд хүнсний аюулгүй байдлын шинэ мэдээллийг системд нэгтгэн хүрээг нь тэлэх байдлаар үргэлжлүүлэн хөгжүүлж байна. Хүнсний аюулгүй байдлын талаарх бүх мэдээллийг агуулсан цахим системийг бий болгох нь цаг хугацаа, нөөц хөрөнгө шаарддаг. Систем нь нэг дор бүгдийг багтаасан цогц бэлэн байх ёсгүй, гэхдээ Гүрж улсын амжилттай хэрэгжүүлсэн шиг алхам алхмаар сайжруулалтыг хийх байдлаар хөгжүүлэх боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрөх нь чухал юм.

Талархал

Энэхүү баримт бичгийг НҮБ-ын ХХААБ-ын Европ, Төв Азийн бүсийн газар, Хельсинкийн их сургуулийн хамтын ажиллагааны хүрээнд 2022 оны 6-р сард эхлүүлсэн “Хүнсний аюулгүй байдлын менежментийг сайжруулах сайн туршлагыг цуглуулах төслийн санал”-ын хүрээнд боловсруулсан болно. Сайн туршлагын талаарх мэдээллийг Гүржийн Байгаль орчин, хөдөө аж ахуйн яамны Үндэсний хүнсний агентлагийн Tamta Mikanadze-аас хүргэж, Хельсинкийн их сургуулийн Janne Lunden, Ilona Harju нар төслийг боловсруулж, ХХААБ-ын Mary Kenny, Gokce Akbalik and Klaudia Krizsan нар хянасан.

Нэмэлт мэдээлэл

Ашигласан материал:

Гүржийн хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн стратеги 2021–2027. <https://eu4georgia.eu/wp-content/uploads/Agriculture-and-Rural-Development-Strategy-of-Georgia-2021%E2%80%932027.pdf>

Холбоо барих хаяг:

Унгар улсын Будапешт хот дахь НҮБ-ын ХХААБ-ын Европ ба Төв Азийн бүс нутгийн алба

Хүнсний аюулгүй байдал, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудал хариуцсан мэргэжилтэн

Mary Kenny

FAO-RO-Europe@fao.org <https://www.fao.org/europe/en/>

Инно Хими Лаб ХХК – ийн танилцуулга:

Үйлчилгээний нэр төрөл:

- Хүнс, хүрээлэн буй орчны шинжилгээний лабораторийн шинжилгээ
- Химийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бодис, урвалжийн худалдаа
- Химийн тоног төхөөрөмжийн суурилуулалт, засвар үйлчилгээ
- Химич, химийн мэргэжилтний сургалт, зөвлөгөө

Бүтээгдэхүүний нэр төрөл:

- Тоног төхөөрөмж
- Лабораторийн тавилга
- Химийн урвалж, бодис, стандарт уусмал, оношлуур
- Шил сав, дагалдах хэрэгсэл

Хэрэглэгчидийнхээ цаг завьг хэмнэх, тасралтгүй ажиллагааг дэмжих үүднээс www.innochem.mn онлайн худалдааны сайтыг нэвтрүүлээд байна.



Инно лаборатори

- Химийн лабораторийн мэргэжилтнүүдэд өндөр хүчин чадал бүхий тоног төхөөрөмжтэй ажиллах орчин бүрдүүлэх, чадамжийг сайжруулах
- Хүнсний болон хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангахад лабораторийн шинжилгээг олон улсын стандартын дагуу нэвтрүүлж хувь нэмрээ оруулах

Шинжилгээний хүрээ:

- Пестицидийн үлдэгдлийн шинжилгээ
- Усанд болон тосонд уусдаг витамины шинжилгээ
- Хүрээлэн буй орчны бохирдлын шинжилгээ